




Арилжааны мэдээ


- Монголын хөрөнгийн бирж 2019 оны 6 дугаар сарын 17-ны өдрөөс 2019 оны 6 дугаар сарын 21-ний өдрүүдэд 5 удаагийн үнэт цаасны арилжааг зохион байгуулж, өдөрт дунджаар 206 сая төгрөг буюу нийт 1,034,827,241.04 төгрөгийн арилжаа хийсэн байна.
- 2019 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,451,270,880,671.45 төгрөг болсон бол “ТОП 20” индекс 19746.62 нэгж болж өмнөх долоо хоногоос 0.29% хувиар өссөн үзүүлэлттэй байна.

MSE Top 20 индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Монгол банкны USD/MNT ерөнхий харьцаа



Эх сурвалж: Монгол Банк

Тодруулга

Энэхүү арилжааны мэдээ нь зөвхөн арилжааны болон санхүүгийн мэдээлэл өгөх зорилготой бөгөөд аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Энэхүү мэдээнд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “БиДиСек ҮЦК” ХК хариуцлага хүлээхгүй болно.

Зах зээлийн өөрчлөлт

Индекс	Нэгж	% Өөрчлөлт
MSE Top-20 индекс	19746.62	0.29%
MSE A индекс	8805.46	-2.83%
MSE B индекс	7990.13	2.65%

Зах зээлийн хураангуй	Нийт (MNT)
Зах зээлийн үнэлгээ	2,451,270,880,671.45
Арилжигдсан үнийн дүн	1,034 сая төгрөг

Үнийн дүнгээр	Хаалт (MNT)	Мөнгөн дүн
ЛЭНДМН ББСБ ХК	60.00	342,131,541.22
АРД ДААТГАЛ ХК	669.34	125,564,700.36
АРД КРЕДИТ ББСБ ХК	74.89	124,227,620.25
Инвекор ББСБ	1810	95,009,830.00
МОНОС ХҮНС	71.43	84,371,227.11

Тоо ширхэгээр	Хаалт (MNT)	Нийт
ЛЭНДМН ББСБ ХК	60.00	6,006,668.00
АРД КРЕДИТ ББСБ ХК	74.89	1,745,232.00
МОНОС ХҮНС	71.43	1,184,007.00
АРД ДААТГАЛ ХК	669.34	200,239.00
ГОВЬ	287.00	180,568.00

Ханш өссөн	Хаалт (MNT)	% Өөрчлөлт
ДАРХАН ЗОЧИД БУУДАЛ	115	22.34
ТҮМЭН ШУВУУТ	187.56	15.42
ХҮННУ МЕНЕЖМЕНТ	212.75	15.00
Э-ТРАНС ЛОЖИСТИКС	100	13.64
БИ ДИ СЕК	887.01	8.97

Ханш буурсан	Хаалт (MNT)	% Өөрчлөлт
МИК ХОЛДИНГ	10600	-15.20
ХӨХ ГАН	73.6	-9.12
МЕРЕКС	25	-7.41
БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	27180	-5.95
МАХИМПЕКС	2500	-4.32



ЭНЭ ДОЛОО ХОНОГТ

“ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН”-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН АНХААРЛАД (mse.mn)

“Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн” (TSX:ERD | MSE:ERDN)-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2019 оны 6-р сарын 20-ны өдрийн 17:00 цагт (Атлантын зуны цагаар) Канад улсын Нова Скошиа мужийн Халифакс хотын Пурдис Варф Тауэрт зохион байгуулагдах бөгөөд хуралд биечлэн оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчид болон хөрөнгө оруулагчдад зориулан компанийн www.erdene.com вебсайт дээр байрлах вебкастаар дамжуулан хурлын үйл ажиллагааг сонсох боломжийг олгож байгаа тухай мэдэгдлээ.

Хурлаар Хөндий Алтны Төслийн урьдчилсан ТЭЗҮ судалгааны явц, сүүлийн өрөмдлөгийн үр дүн, Хөндий Алтны Дүүрэгт хайгуулын үйл ажиллагааг цаашид өргөжүүлэх боломжууд зэрэг мэдээллүүдийг танилцуулна.

Мэдээллийн дэлгэрэнгүйг **Энд** дарж үзнэ үү.

СЗХ: “МИК АКТИВ 19” ХХК-Д ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААС ГАРГАХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОЛОО. (bloombergtv.mn)

Мөн үнэт цаасны салбарын дөрвөн асуудал хэлэлцсэнээс “МИК Актив 19” ХХК-д хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож, тус компанийн гаргасан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэсэн байна.

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГУУД ЗАХ ЗЭЭЛИЙН ТУЛГАМДСАН АСУУДЛААР СЗХ-НД ХҮСЭЛТ ХҮРГҮҮЛЛЭЭ. (mse.mn)

Монголын хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн байгууллагуудын төлөөлөл болох “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК, “Арилжааны төлбөр тооцоо” ХХК, “Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо” ЭЗБ хамтран, дотоодын хөрөнгийн зах зээлийг дараагийн шатанд хүргэж хөгжүүлэхэд тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлүүлэх талаар хүсэлтийг 2019 оны 6 дугаар сарын 14-ний өдөр Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүллээ.

Энэхүү хүсэлтэнд:

Хөрөнгө оруулагчдад арилжааны таатай орчин нөхцөл бүрдүүлэхэд чухал ач холбогдол бүхий төлбөр тооцооны дараа төлбөрт Т+2 горимд шилжих, Хөрөнгийн биржид бүртгэлтэй боловч арилжааны хөрвөх чадвар сул, дансны болон зах зээлийн үнэлгээ нь хэт зөрүүтэй компаниудын үнэлгээг бодитой болгоход чиглэсэн арга хэмжээ авах,

Тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс төвлөрүүлдэг Санхүүгийн зохицуулах хорооны “зохицуулах үйлчилгээний хөлс”-ийг бууруулах эсвэл хөнгөлж мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зэрэг асуудлуудыг тусгасан байна.

Ийнхүү зах зээлд тулгамдаж байгаа асуудлуудыг шийдвэрлэснээр, хөрөнгийн зах зээлийн арилжааны хэмжээ нэмэгдэх, хувьцаат компаниудын хөрвөх чадвар сайжрах, хөрөнгө оруулагчдад ээлтэй арилжааны орчин бий болох, улмаар дотоодын хөрөнгийн зах зээл олон улсын стандартад нийцэж албан ёсны олон улсын зах зээлийн зэрэглэлтэй болоход ихээхэн чухал ач холбогдолтой юм.

“ERDENE RESOURCE DEVELOPMENT”-ИЙН ТУЗ-ИЙН ТЭРГҮҮНЭЭР ЛЭЙТОН КРОФТ СОНГОГДОВ. (bloombergtv.mn)

Торонто болон Монголын Хөрөнгийн биржид давхар бүртгэлтэй “Erdene Resource Development” компанийн ТУЗ-ийн тэргүүнээр Лэйтон Крофт сонгогдлоо.

Тэрбээр Монголд 25 жил ажилласан туршлагатай, 2015 оны

Тэрбээр Монголд 25 жил ажилласан туршлагатай, 2015 оны зургаадугаар сараас эхлэн компанид захирлын түвшинд ажиллаж байгаа талаар тус компани мэдэгдлээ. Үүний зэрэгцээ “Erdene Resource Development”-ийн хувьцааны ханш 2.56 хувиар өсөж, 0.2 канад доллар болсноор баасан гарагийн арилжааг дуусгасан байна. “Erdene Resource Development”-ийн хувьд хаалттай хүрээнд 10 сая ширхэг үнэт цаас гаргаж, хоёр сая канад доллар татан төвлөрүүлэхээр болжээ. Санхүүжилт татах хугацаа зургаадугаар сарын 26-нд дуусгавар болох юм.

“МАШИН МЕХАНИЗМ” ХК-ИЙН НОГДОЛ ХУВИЙГ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ДАНСАНД БАЙРШУУЛЛАА. (schcd.mn)

“Машин механизм” ХК-ийн хувьцааг эргүүлэн худалдан авах зорилгоор ногдол хувь болох нэгж хувьцаанд 1100 төгрөг тараасныг 2019 оны 06 дугаар сарын 21-ны өдөр хувьцаа эзэмшигчдийн төвлөрсөн хадгаламжийн дансанд байршууллаа.

“МОНГОЛ БАЗАЛТ” ХК-ИЙН 2018 ОНЫ НОГДОЛ АШГИЙГ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ДАНСАНД БАЙРШУУЛЛАА. (schcd.mn)

“Монгол базалт” ХК-ийн 2018 оны ногдол ашиг болох нэгж хувьцаанд 3 төгрөг 30 мөнгө тараасныг 2019 оны 06 дугаар сарын 24-ны өдөр хувьцаа эзэмшигчдийн төвлөрсөн хадгаламжийн дансанд байршууллаа.

“ERDENE RESOURCE DEVELOPMENT”-ИЙН ХААЛТТАЙ САНХҮҮЖИЛТ ТАТАХ ХУГАЦАА VI/ 26-НД ДУУСНА. (bloombergtv.mn)

“Erdene Resource Development” компанийн хувьцааны ханш пүрэв гарагийн арилжаагаар 10.5 хувиар өсөж, 0.17 канад доллар боллоо.

Харин Монголын Хөрөнгийн биржид өнөөдрийн арилжаагаар тус компанийн хувьцаан ханш 1.9 хувиар өсөж, 479 төгрөг болсон байна. “Erdene Resource Development” компани хаалттай хүрээнд 10 сая ширхэг үнэт цаасыг нэгж бүрийг нь 0.2 канад доллароор үнэлэн нийт хоёр сая канад долларыг татан төвлөрүүлэхээр зорьж байгаа юм. Энэхүү санхүүжилтийг “Хөндий” төслийн хараат бус урьдчилсан ТЭЗҮ боловсруулах, “Баян хөндий” төслийн ашиглалтын лиценз авах бэлтгэл ажил зэрэгт зарцуулахаар төлөвлөсөн талаар тус компани мэдээллээ. Энэхүү хаалттай санхүүжилт татах хугацаа зургаадугаар сарын 26-нд дуусна.

“CERBERUS CAPITAL MANAGEMENT” ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН “MCS GROUP”-ТЭЙ 110 САЯ АМ.ДОЛЛАРЫН ХЭЛЦЭЛ ХИЙЖ МАГАДГҮЙ. (bloombergtv.mn)

Нью-Йоркт төвтэй “Cerberus Capital Management” хувийн хөрөнгө оруулалтын сан “MCS Group”-ийн хоёр компанийн хувьцааг худалдан авахаар яриа хэлэлцээ хийж байгаа тухай “Wall Street Journal” мэдээллээ.

Эх сурвалжийн мэдээлэлд дурдсанаар “MCS Group”-ийн харилцаа холбооны болон өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниудын 25 хувийг худалдан авахаар 110 сая ам.доллар санал болгож магадгүй гэж мэдээлсэн байна.

“Cerberus Capital Management” хувийн хөрөнгө оруулалтын сан нь “Deutsche Bank” болон “Avon Products” компаниудад хөрөнгө оруулсан ба нийт 39 тэрбум ам.долларын позицгийг удирддаг юм байна. Хэрэв хэлцэл биелбэл тус компанийн Монголд хийсэн анхны хөрөнгө оруулалт болох аж.



О.Уранбайгаль

Харилцагчийн албаны менежер
И-мэйл: baigal@bdsec.mn

БиДиСек төв оффис

Залуучуудын өргөн чөлөө 27-1
8-р хороо, Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар, Монгол улс
Утас: 976-7555-1919
Факс: 976-11-321763

Д.Шүрэнцэцэг

Харилцагчийн алба, мэргэжилтэн
И-мэйл: shurentsetsegd@bdsec.mn

БиДиСек төв оффис

Залуучуудын өргөн чөлөө 27-1
8-р хороо, Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар, Монгол улс
Утас: 976-7555-1919
Факс: 976-11-321763

Б.Онон

Харилцагчийн алба, мэргэжилтэн
И-мэйл: Onon.b@bdsec.mn

БиДиСек төв оффис

Залуучуудын өргөн чөлөө 27-1
8-р хороо, Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар, Монгол улс
Утас: 976-7555-1919
Факс: 976-11-321763

Энэхүү арилжааны мэдээ нь зөвхөн арилжааны болон санхүүгийн мэдээлэл өгөх зорилготой бөгөөд аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Энэхүү мэдээнд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “БиДиСек ҮЦК” ХК хариуцлага хүлээхгүй болно.